

“ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС” ХК

2024 оны 04 дүгээр сарын 30-ний өдөр

№ ХТ 01/2024

Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2024 оны 04 дүгээр сарын 30-ний өдрийн 12.00 цагаас 12.30 цагийн хооронд <https://meet.google.com/kds-kudc-gvb> програмыг ашиглан хуралдав.

Хурал зохион байгуулах комисс болон Тооллогын комиссоос хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцохоор ирсэн хувьцаа эзэмшигчдийн ирцийг бүртгэж, 132'924'866 /нэг зуун гучин хоёр сая есөн зуун хорин дөрвөн мянга найман зуун жаран зургаа/ ширхэг буюу ширхэг саналын эрхтэй хувьцааг буюу 75.71 /далан тав зууны далан нэгэн/ хувийг эзэмшигчид оролцож байгаа талаар танилцуулж, хурлын ирц компанийн дүрэм болон хуулийн дагуу бүрдсэн тул хурал хүчин төгөлдөрт болсон тухай Тооллогын комиссын шийдвэрийг танилцуулав. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд Субашид тек ХХК-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал Т. Золбоо, хувьцаа эзэмшигч Г. Дулмааг төлөөлж иргэн Б.Батхүү нар итгэмжлэлээр хуралд оролцов. Компанийн зүгээс цахим хурлыг бичлэг хийж хадгалав.

Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах шийдвэрийн 2 дугаар хавсралтад заасан “Хурлын хөтөлбөр, дэг”-ийн дагуу хэлэлцэх асуудлын эхэнд хувьцаа эзэмшигчдээс хурлын даргыг сонгов.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэв.Үүнд:

1. Компанийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн тайланд аудит хийлгэсэн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай,
2. Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэж батлах тухай;

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Т.Золбоо хувьцаа эзэмшигчдийн хурлын хөтөлбөрийн дагуу хурлыг нээж хурлаар компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайланг танилцуулахыг Гүйцэтгэх захирал Ц.Хүдэрмөнхөөс хүсэв.

Ц.Хүдэрмөнх: Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан хувьцаа эзэмшигчдийн хурлын материал болон МХБ-ын сайтад тавигдсан байгаа байх. Хувьцаа эзэмшигчид уншиж танилцсан байхаа. Гол хэсгүүдийг уншиж танилцуулья.

1,2-р хэлэлцэх асуудлаар:

Компанийн санхүүгийн тайланг тараасан танилцсан байх. Програм хангамж саяхан хий дууссан болохоор энэ жил илүү борлуулалтандаа анхаарна. Хувьцаа эзэмшигчид тодруулах зүйл байна уу.

Хурлын дарга Ц. Золбоо: Хөтөлбөрийн дагуу хэлэлцэж буй асуудлуудтай холбоотой санал, асуулга явуулья.

Хувьцаа эзэмшигчидээс ямар нэгэн санал, асуулга явагдсангүй тул санал хэлэлцэж байгаа асуудлаар санал хураалт явуулья.Хэлэлцэх асуудал тус бүрийг цахимаар гар өргөж санал за өгнө үү. Тооллогын комисс үүнийг бүртгэж авна уу.

2024 ОНЫ 04-Р САРЫН 30-НИЙ ӨДРИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ДАРГА

/ Т. ЗОЛБОО/



Тооллогын комиссын дарга Г. Төгөлдөр: Тооллогын комиссын тогтоолыг танилцуулав. Хуралд оролцож буй санал өгсөн саналыг тоолоход хүчингүй болсон, түдгэлзсэн, эсрэг санал гарсангүй. Санал дараах байдлтай байна. Үүнд:

№	Хэлэлцсэн асуудлууд	Ээлжит хуралд оролцож буй санал өгөх эрхтэй хувьцаа эзэмшигчдийн								Нийт	
		Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн		Хүчингүй болсон			
		ширхэг	хувь	ширхэг	хувь	ширхэг	хувь	ширхэг	хувь	ширхэг	хувь
1	Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайланг батлах тухай	132'924'866	100%							132'924'866	100%
2	Компанийн 2023 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг батлах тухай	132'924'866	100%							132'924'866	100%

Хурлын дарга Т.Золбоо: Хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчид 100% санал нэгтгэйгээр хэлэлцэж буй асуудлуудыг дэмжсэн байна. Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төсөлд ямар нэгэн санал байна уу.

Хувьцаа эзэмшигчид 100% санал нэгтгэйгээр саналгүй тул Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарч буй шийдвэрийг уншиж танилцуулав.

“ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС” ХК-НЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИДИЙН 2024 ОНЫ 04-Р САРЫН 30-НИЙ ӨДРИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААС ДАРААХ АСУУДЛУУДЫГ ШИЙДВЭРЛЭВ. ҮҮНД:

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэж батлав;
2. Компанийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн тайланд аудит хийлгэсэн дүгнэлтийг хэлэлцэж батлав.

ХУРЛЫН ДАРГА



/ Т.ЗОЛБОО/

2024 ОНЫ 04-Р САРЫН 30-НИЙ ӨДРИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ДАРГА

 2

/ Т.ЗОЛБОО/